



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/553

Зуунмод

Зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Нийтийн номын сангийн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд БНСУ-ын Пёнтек хотын захирагч Жон Жансон болон бусад албаны хүмүүс Төв аймагт айлчлахтай холбоотой шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 3,336,260 (гурван сая гурван зуун гучин зургаан мянга хоёр зуун жар) төгрөгийг аймгийн төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны  
10 дугаар сарын 03 -ны өдрийн  
А/553 дугаар захирамжийн хавсралт



БНСУ-ЫН ПЁНТЕК ХОТЫН ЗАХИРАГЧ  
ЖОН ЖАНСОН БОЛОН ХОТЫН ЗАХИРГААНЫ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТӨВ АЙМАГТ  
АЙЛЧЛАХ ҮЕД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Үйлчилгээний нэр	Хүний тоо	Үнэ	Нийт үнэ
1	Нисэх буудалын угтаж авах үйлчилгээ (ВИП)	5	300,000	1,500,000
2	Нисэх буудалын угтаж авах үйлчилгээ (ВИП)	4	100,000	400,000
3	Нисэх буудалын үдэж гаргах үйлчилгээ (Бизнес лоунж)	14	90,000	1,260,000
4	Нисэх буудалын үдэж гаргах үйлчилгээ (Бизнес лоунж тусгай өрөө)	2	35,000	70,000
5	Орчуулагч	1	106,260	106,260
		Нийт		3,336,260 төгрөг

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

